



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 01

Номгон

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний
тухай

Сүүлийн жилүүдэд Улсын хэмжээнд жил бүрийн хавар, намрын хуурайшилтын улиралд ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч, орон нутгийн, нийгэм эдийн засаг, байгаль орчинд ихээхэн хэмжээний хохирол учруулсаар байгаа бөгөөд Монгол Улсын хэмжээнд 2021 онд гарсан ой, хээрийн гал түймрийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 63 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн Цаг уур орчны шинжилгээний байгууллагаас ирүүлсэн цаг агаарын урьдчилсан мэдээгээр энэ оны хавар, намар, хур тунадас багатай, хуурайшилт ихтэй байх мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлсээр байна.

Иймд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1, Улсын Онцгой комиссын 2023 оны "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгавар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 2023 оны 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн аймгийн хэмжээнд ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга (дэд хурандаа Б.Мягмарсүрэн)-д:

1.1 Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтантай хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах, шаардлагатай техник, багаж хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авах.

1.2 Аймаг сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед сум, орон нутгаас дайчлан ажиллуулах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, мэргэжлийн удирдлагаар ханган, гал түймрийн улсын хяналт, шалгалтыг эрчимжүүлэх.

Хоёр. Цагдаагийн газрын дарга, (Цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхбаяр)-д:

2.1 Ой, хээрийн гал түймэр гарсан тохиолдолд шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, холбогдох байгууллагуудад мэдээлэх;

2.2.Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий сумдад, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох, төрийн байгууллагуудтай хамтран байнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэгийг ажиллуулах;

2.3.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/10, А/16 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журам”-ын хэрэгжилтийг хангах;

Гурав. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Э.Ганзориг)-т:

3.1 Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хуульд заасан шаардлага биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд холбогдох дүрэм журмын хүрээнд хариуцлага тооцох;

3.2 Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ой сан бүхий газарт тээврийн хэрэгсэл нэвтэрч болох газруудад зурвас шуудуу гарган, автомашины саад, сэрэмжлүүлэх самбаруудыг нэмэлтээр байрлуулж хяналт тавьж ажиллахыг;

3.3 Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг тогтмол явуулж хэвших;

Дөрөв. Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч (хурандаа Ц.Батхүү)-д:

4.1 Аймгийн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үүрэг гүйцэтгэх хүн, хүч шаардагдах техник, багаж хэрэгслээр дэмжлэг үзүүлж, бэлэн байдлыг хангаж ажиллах;

Тав. Эрүүл мэндийн газрын дарга (Н.Энхжаргал)-д:

5.1 Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч томилгоот бүрэлдэхүүн 7 хоногоос дээш хугацаагаар ажиллах мөн дайчлагдан ажиллаж байгаа бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эмнэлгийн баг томилгоожуулан ажиллуулах;

Зургаа. Сумдын Засаг дарга, Онцгой Комиссын дарга нарт:

6.1. Ой, хээрийн гал түймэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг тухай бүрт нь Онцгой байдлын газарт ирүүлэх;

6.2. Ой, хээрийн гал түймрийг унтраах, хор уршгийг арилгах ажиллагаанд татан оролцуулах гамшгаас хамгаалах ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн хүч хэрэгслийг тодотгож, ой, хээрийн гал түймрийн үед үүрэг гүйцэтгэх чиглэлээр чадавхжуулах сургалт, дадлагыг зохион байгуулах;

6.3 Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг томилгоожуулан “Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 38 дугаар тушаал”-ын 2.2-т заасны дагуу шаардлагатай зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлж ажиллах;

6.4 Сумын нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймэр гарсан үед Онцгой байдлын газарт мэдэгдэж, бүрэн эрхийнхээ хүрээнд хүч хэрэгслийг дайчлан, гарсан гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах;

6.5.Нутаг дэвсгэрийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, шаардлагатай багаж, хэрэгслийг бэлтгэх, бэлэн байдлыг хангах;

6.6.Сумдын Засаг дарга нар 2 дугаар сарын 20–ны өдрөөс 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хуурайшилтын “аюултай” “нэн аюултай” зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг түр хязгаарлах тухай захирамж гарган хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах;

6.7. Албан даалгаврын хэрэгжилтийн эхний хагас жилийн мэдээ тайланг 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг 11 дүгээр сарын 18-ны өдрийн дотор албан бичигтэй, илтгэх хуудсаар Онцгой байдлын газар, Цагдаагийн газарт ирүүлж ажиллахыг тус тус үүрэг болгосугай;

Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, Тайлан мэдээг заасан хугацаанд ирүүлээгүй буюу хоцроосон тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН